



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙГ ӨНДӨР ҮНЭЭР ИРГЭДЭД ХУДАЛДАЖ,
ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ГАЗАРТ БАЙРШУУЛАХ НӨХЦӨЛ БҮРДҮҮЛСЭН ЭСЭХЭД
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**



**БАТЛАГДСАН БАЙРШИЛД ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ТҮРГЭН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ БАЙРШУУЛСАН, НЭГ КОМПАНИД
ХУДАЛДАХ ДАВУУ ЭРХ ОЛГОХ ЧИГЛЭЛ БАРИМТАЛСАН НЬ
ИРГЭДИЙГ ХОХИРООХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА**

Улаанбаатар хот
2017 он



Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Нийцлийн аудитын
газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор
Б.Алтанзул

Ахлах аудитор
Я.Наранцэцэг

Аудитор
Л.Нямтөмөр

2017 оны 5 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас
үзнэ үү.
www.audit.mn

Аудитын тайлан дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 261729, 260949
дугаарын утас, факсаар
харилцана уу.

Хаяг:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу-3
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Аудит хийхэд ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	3
Үндсэн мэдээлэл	4-5
НЭГ.“Нийслэлийн нутаг дэвсгэрт ТҮЦ ажиллуулахаар гаргасан журам”-ын зарим шаардлага нь хууль тогтоомжтой нийцээгүй байна.....	6
ХОЁР. БЗД, БГД, СБД-ийн ХҮЗЗ “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ын заалтыг зөрчиж зөвшөөрөгдсөн байршилд давхардуулан, батлагдсан тооноос илүү ТҮЦ байршуулах зөвшөөрөл олгожээ.....	7-8
ГУРАВ. ТҮЦ эзэмшигчдийг сонгон шалгаруулах талаар журамд тусгаагүй бөгөөд зохицуулалтгүй байна.....	9
ДӨРӨВ. Өрсөлдөөнийг хязгаарласан нь иргэдийг хохироох нөхцөлийг бүрдүүлжээ.....	10-11
ТАВ. Орон нутгийн төсөвт түргэн үйлчилгээний цэгээс газар ашигласны төлбөр, хүн амын орлогын албан татвар, зарим дүүрэгт хураамжийн орлого төвлөрүүлдэг байна.....	12-13
Холбогдох байгууллагын санал.....	14-20
Дүгнэлт	21
Зөвлөмж.....	22
Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал.....	23



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГ	Засгийн Газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НЕТГ	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НИТХТ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТҮЦ	Түргэн үйлчилгээний цэг
УБ	Улаанбаатар
ХУД	Хан-Уул дүүрэг
ХҮЗЗ	Худалдаа үйлчилгээний зохицуулах зөвлөл
ЧД	Чингэлтэй дүүрэг

ХҮСНЭГТ, ЗУРАГ, ГРАФИК МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

График №1	Нийслэлийн төвийн 6 дүүргийн түргэн үйлчилгээний цэгийн тоо
Хүснэгт №1	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн захирамжийн мэдээлэл
Зураг №1	Зөвшөөрөлгүй давхцаж байршсан ТҮЦ
Хүснэгт №2	УБ хотын ЗАА-аас албан бичгээр өгсөн чиглэл
Зураг №2	“КИГ” ХХК-ийн хийсэн чанар муу ТҮЦ
Хүснэгт №3	“ЭМ КЭЙ ТИ АР ЭС” ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайлан
Хүснэгт №4	Гэрээ байгуулсны хураамжийн хэмжээ болон төлсөн байдал
Хүснэгт №5	2013-2016 оны газрын төлбөрийн хэмжээ



Аудит хийх үндэслэл:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01/145 албан бичгийг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1. Аудитын нэр: Түргэн үйлчилгээний цэгийг өндөр үнээр иргэдэд худалдаж, зөвшөөрөлгүй газарт байршуулах нөхцөл бүрдүүлсэн эсэх.

2. Аудитын код: YAГ-НАГ/2017/10-ЭА

3. Аудитын зорилт:

Түргэн үйлчилгээний цэгийг өндөр үнээр иргэдэд худалдаж, зөвшөөрөлгүй газарт байршуулах нөхцөл бүрдүүлсэн эсэхэд холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт гарган санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Нийслэлийн нутаг дэвсгэрт ТҮЦ ажиллуулахаар гаргасан шийдвэр нь холбогдох хууль, тогтоомжтой нийцсэн эсэх;
- Дүүргүүдийн "Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн гаргасан шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх;
- Дүүргүүд батлагдсан тооноос илүү, зөвшөөрөгдсөн байршилд ТҮЦ-ийг байршуулсан эсэх;
- ТҮЦ эзэмшигчдийг хууль журмын дагуу сонгон шалгаруулсан эсэх;
- ТҮЦ-ийн төсөвт өртгийг бодитой тооцож, үнэлсэн эсэх;
- ТҮЦ-ээс төсөвт төвлөрүүлэх орлого бүрэн төвлөрсөн эсэх.

4. Хамрах хүрээ:

Аудитад НИТХ-ын Ажлын алба, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Захирагчийн ажлын алба, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Дүүргийн ЗДТГ, Худалдаа, үйлчилгээний хэлтэс, Худалдаа, үйлчилгээний Зохицуулах зөвлөл, ТҮЦ эрхлэгч иргэдийн төлөөлөгчдийг хамруулан нийслэлийн нутаг дэвсгэр дэх ТҮЦ-ийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэхийг авч үзлээ.

5. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000, АДБОУС 4100, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, асуулга, лавлагаа, тайлбар, мэдээ гаргуулах, нотлох баримтыг баталгаажуулах, санхүүгийн болон хяналтын тайланг судлах зэрэг аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийж зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалган баталгаажуулав.

6. Аудит хийхэд ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Газрын төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйл;
- Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1;



- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2;
- Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7;
- Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 7 дугаар зүйлийн 7.1, 13 дугаар зүйлийн 13.1;
- Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоол;
- НИТХТ-ийн 2010 оны 198 дугаар тогтоол;
- НИТХТ-ийн 2014 оны 7 дугаар тогтоол;
- НИТХ-ын 2010 оны 5/39 дүгээр тогтоол;
- НИТХТ-ийн 2014 оны 56 дугаар тогтоол;
- НИТХТ-ийн 2017 оны 61 дүгээр тогтоол;
- Нийслэлийн ЗД-ын 2013 оны А/1030 дугаар захирамж;
- Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2015 оны А/36, А/73, А/135, 2016 оны А/93 дугаар захирамж.

7. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, аудит хийсэн хугацаа:

Аудитыг ҮАГ-ын НАГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Алтанзул хянан удирдаж, төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатыг 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөс 4 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл аудитор М.Туул, 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн Ахлах аудитор Я.Наранцэцэг, аудитор Л.Нямтөмөр нар гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатыг 5 дугаар сарын 5-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэв.

8. Үндсэн мэдээлэл:


Түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагааг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 198 дугаар тогтоолоор “Нийтлэг үйлчилгээний журам”-аар зохицуулж байгаад, 2014 оны 56 дугаар тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ыг баталж, 2014 оны 8 дугаар сарын 1-нээс хэрэгжүүлсэн байна.

Дээрх журмыг үндэслэн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2015 оны А/36, А/73, А/135, 2016 оны А/93 захирамжуудаар дүүргүүдэд байршуулах нийт 357 ширхэг “түргэн үйлчилгээний цэг”-ийн буюу ТҮЦ-ийн тоог баталж, батлагдсан тоонд багтаан түргэн үйлчилгээний цэгүүдийг байршуулж, холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, өмнө нь ажиллаж байсан түргэн үйлчилгээний цэгүүдэд байршил олгохыг дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа, үйлчилгээг зохицуулах Зөвлөлд даалгасан байна.

Аудитын явцад нийслэлд нийт 838 ТҮЦ бүртгэгдсэнээс УБ хотын Ерөнхий менежерийн захирамжийн дагуу зөвшөөрөгдсөн байршилд 357 ТҮЦ байршихаас 249 байршсан, зөвшөөрөлгүй байршилд 589 ТҮЦ байршсан байгаа гэсэн байна. Нийслэлийн төвийн 6 дүүргийн түргэн үйлчилгээний цэгийн тоо диаграмаар үзүүлэв.



График №1 Нийслэлийн төвийн 6 дүүргийн түргэн үйлчилгээний цэгийн тоо



Эх сурвалж: Дүүргийн ХҮХ-ийн судалгаа



НЭГ. “Нийслэлийн нутаг дэвсгэрт ТҮЦ ажиллуулахаар гаргасан журам”-ын зарим шаардлага нь хууль тогтоомжтой нийцээгүй байна

1.1. Түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагааг НИТХТ-ийн 2010 оны 198, 2014 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”-аар зохицуулж байгаад НИТХТ-ийн 2014 оны 56 дугаар тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ыг нийтлэг журмаас тусад нь батлан гаргаж, 2014 оны 8 дугаар сарын 1-нээс мөрдөж эхэлсэн байна.

Энэхүү журмаар ТҮЦ-д тавигдах шаардлага, худалдаалах бараа бүтээгдэхүүн, хориглох зүйл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үүрэг, хүлээлгэх хариуцлага, түүнд тавих хяналтын талаар тодруулж өгснөөр нийтлэг журмаас онцлог болсон байна.

Энэ журмыг боловсруулахдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 99 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-д заасан дагуу хийгээгүй боловсруулагдсан нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журамтай нийцүүлээгүй учраас тухайн журам бүхэлдээ хүчин төгөлдөр бус гэж үзэхээр байна.

1.2. ЗАА-ны ХХҮХ Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний газраас боловсруулж санал болгосон ТҮЦ-ийн загварыг дэмжилгүй, өөр компанийн боловсруулсан загварын шийдлийг дэмжиж “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ын 2.1.5-д “зөөврийн бие засах суултуур бүхий ариун цэврийн өрөөтэй байх” шаардлага тусгаж өгсөн байна.

ТҮЦ-д тавигдсан шаардлагын биелэлтийг дүүрэг бүрээр гаргахад зөөврийн бие засах суултуур бүхий ариун цэврийн өрөөтэй байх ба түүнд ашиглах цэвэр ус, үнэр дарагч болон халдваргүйжүүлэх бодисын нөөцтэй, бохир нөөцлөх сав 10-аас доошгүй байх, мөн бохирыг зайлуулах гэрээ байгуулсан байх гэсэн 2 шаардлага хэрэгжээгүй байна.

НМХГ-аас 2013 оны 02-03/2435 дугаар албан бичгээр ТҮЦ-ийг Монгол Улсад мөрдөгдөж буй “MNS4946:2005” стандартад тусгагдсан халаалттай байх, 20м²-аас доошгүй худалдааны танхимтай байх тухай хүргүүлсээр байхад ЗАА-ны ХХҮХ дээрх журмыг батлуулсан нь үйлчилгээний барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлагыг тодорхойлсон Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹, 5.3², 7 дугаар зүйлийн 7.1³ дэх заалтыг тус тус зөрчиж, “MNS4946:2005” стандартыг баримтлахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.3. 2017 оны 4 дүгээр сарын 18-ны НИТХТ-ийн 2017 оны А/61 дүгээр тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулахад дагаж мөрдөх журам”-ыг шинээр баталж, Хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний нэгдсэн санд бүртгүүлэхээр Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасны дагуу хүргүүлсэн боловч зохих шаардлагыг хангаагүйгээс бүртгээгүй байна.

Энэхүү шинэ журманд хуучин журмаар хэрэгжихгүй байсан зарим заалтыг өөрчилж, зарим шаардлагыг хэрэгжих боломжтой байдлаар, ТҮЦ эрхлэгчдийн эрх, үүргийг тодорхойлж тусгасан ч ТҮЦ эрхлэх зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалт ил тод, нээлттэй байхаар тодруулсан зохицуулалт тусгаагүй, ТҮЦ-ийн талбайн хэмжээ “MNS4946:2005” стандарт зөрчсөн заалтыг өөрчлөөгүй байна.

¹ Хот, суурин газрын төлөвлөлт, барилга байгууламж нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, эрүүл ахуйн нөхцөл, барилгын норм, нормативын шаардлагыг хангасан байна.

² Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна.

³ Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж нь эрх бүхий байгууллагаас хянаж баталгаажуулсан зураг төслийн дагуу баригдсан, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.



ХОЁР. БЗД, БГД, СБД-ийн ХҮЗЗ “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ын заалтыг зөрчиж зөвшөөрөгдсөн байршилд давхардуулан, батлагдсан тооноос илүү ТҮЦ байршуулах зөвшөөрөл олгожээ

2.1. Нийслэлийн төвийн 6 дүүргийн Засаг дарга нар ХҮЗЗ байгуулах тухай захирамжаар ХҮЗЗ-ийн бүрэлдэхүүн, дүрмийг баталжээ. ХҮЗЗ нь НИТХТ-ийн 2014 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт ТҮЦ ажиллуулах журам”-ын 1.3, 5.1, 5.2-д заасны дагуу хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллах үүрэгтэй байна.

2.2. “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ын 2.1.1, 2.1.2-т заасан шаардлагын дагуу дүүргийн Засаг дарга нараас ирүүлсэн саналыг үндэслэн Улаанбаатар хотын Ерөнхий менежер 2015 онд А/36, А/73, А/135, 2016 онд А/93 дугаар захирамжаар нийслэлийн 6 дүүрэгт нийт 357 ТҮЦ байршуулах цэгийг тодорхойлсон шийдвэр гаргасан байна. Мэдээллийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №1 Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн байршил заасан захирамж

№	Захирамж ийн огноо	Захирам жийн дугаар	БГД	СБД	ЧД	СХД	ХУД	БЗД	Нийт
1	2015.03.31	А/36	88	43	40	74	-	-	245
2	2015.06.08	А/73	5	13	-	-	69	-	87
3	2015.11.10	А/135	14	-	-	-	-	11	25
4	2016.07.06	А/93	А/36 тушаалын 55 байршил өөрчилсөн	-	А/36 тушаалын 26 байршил өөрчилсөн	-	-	-	-
			107	56	66	74	69	11	357

Эх сурвалж: Нийслэлийн ХХҮХ-ийн ажлын баримт

Дүүргийн ХҮЗЗ УБ хотын Ерөнхий менежерийн захирамжаар батлагдсан байршлын 108 байршилд буюу БГД-т 23, СБД-т 15, ХУД-т 33, ЧД-т 19, СХД-т 18 байршилд ТҮЦ байршуулаагүй нь дээрх захирамж биелэгдээгүй байна.

БГД, ЧД-ийн Засаг дарга нар А36 тушаалд санал болгон батлуулсан байршлаа дахин өөрчилж, А93 тушаал гаргуулсан нь байршлын саналыг холбогдох хэлтэс, нэгжээс бүрэн авч тусгадаггүй, зарим байршилд нь иргэд үйлчилгээ явуулах сонирхолгүй байдагтай холбоотой байна.

2.3. “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам” 2014 онд батлагдсан байтал журмын 1.3-д заасны дагуу БГД, СБД, ЧД-ийн ХҮЗЗ 172 байршилд байрлах ТҮЦ эрхлэгчтэй гэрээ байгуулсан, ХУД-ийн ХҮЗЗ гэрээ байгуулаагүй, БЗД-ийн ХҮЗЗ аудитын шалгалтын явцад 11 гэрээ байгуулсан нь дүүргүүдийн ХҮЗЗ журмыг харилцан адилгүй хэрэгжүүлсэн байна.

2.4. УБ хотын Ерөнхий менежерийн батлагдсан байршилд давхардуулан БЗД, БГД-ийн ХҮЗЗ 14 ТҮЦ-д, уг батлагдсан байршлаас гадна ЧД, СБД-ийн ХҮЗЗ 89 байршилд тус тус зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан нь “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ын 2.1.1 дэх заалтыг зөрчиж ТҮЦ-ийн тоог нэмэгдүүлсэн байна. Зөвшөөрөлгүй давхцаж байршсан ТҮЦ-ийг зургаар үзүүлэв.



Зураг №1 Зөвшөөрөлгүй давхцаж байршсан ТҮЦ



Эх сурвалж: Аудитын багийн авсан зураг.

2.5. Нийслэлийн төвийн 6 дүүргийн ХҮХ-ээс аудитын явцад гаргасан судалгаагаар нийслэлд нийт 838 ТҮЦ бүртгэгдсэнээс зөвшөөрөгдсөн байршилд 249, зөвшөөрөлгүй байршилд 589 ТҮЦ байршсан байгаа нь журмын 2.1.2 дахь заалтыг зөрчсөн байна.

2.6. “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ын 2.1.3-т ТҮЦ эрхлэгчид нь тухайн дүүргийн ЗД-ын дэргэдэх ХҮЗЗ-ийн даргатай гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна. Гэрээг жил бүр дүгнэж, Зөвлөлийн хурлаар хэлэлцэн хугацааг нэг жилээр сунгаж болно” гэж заасныг зөрчиж, УБ хотын ЗАА-аас журмыг шинэчилнэ гэсэн шалтгаанаар гэрээ байгуулахгүй байхаар чиглэл өгсний дагуу дүүргийн ХҮЗЗ үйлчилгээ эрхлэгч нартай гэрээ байгуулаагүй, гэрээ байгуулсан ч дүгнэж сунгаагүй нь ТҮЦ эрхлэгчдийн эрх ашигт нийцээгүй, нөгөө талаас гэрээгүй, зөвшөөрөлгүй ТҮЦ байршуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.



ГУРАВ. ТҮЦ эзэмшигчдийг сонгон шалгаруулах талаар журамд тусгаагүй бөгөөд зохицуулалтгүй байна

3.1. ТҮЦ эрхлэгчдийг сонгон шалгаруулах ажлыг ХҮЗЗ зохион байгуулаагүй, “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-д энэ талаар зохицуулалт тусгаагүй, зөвхөн иргэдийн өргөдөл, хүсэлт, УБ хотын ЗАА-аас албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу зөвшөөрөл олгож гэрээ байгуулдаг байна. УБ хотын ЗАА-аас албан бичгээр өгсөн чиглэлийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №2 УБ хотын ЗАА-аас албан бичгээр өгсөн чиглэл

Д/д	Огноо	№	Нийслэлээс өгсөн чиглэл
1	2014.04.29	05/714	Одоо ажиллаж байгаа ТҮЦ-ийн загвар дизайныг батлагдсан зураг төсвийн дагуу шинэчлэх, үе шаттайгаар эхлүүлэх,
2	2015.05.16	01/802	Автобусны зогсоолд ТҮЦ байрлуулах зөвшөөрөл олгохгүй байх, одоо байршиж байгаа ТҮЦ-ийг өөр газар холдуулан шилжүүлэх тухай,
3	2014.07.31	01/1205	ТҮЦ-ийн загвар төслийг Зөвлөлөөр хэлэлцэж НЕТГ-аар батлуулах, Одоо ажиллаж байгаа ТҮЦ-ийн загварыг шинэчлэх ажлыг хотын А бүсээс эхлэх, уг бүсэд зориулалтын ариун цэврийн өрөө бүхий ТҮЦ байршуулах, Гэр хороололд ТҮЦ-ийн загвар шинэчлэх ажлыг шат дараатай зохион байгуулах,
4	2015.01.10	01/85	НЕТГ-аас баталсан загварын дагуу хотын А, Б бүсэд байгаа ТҮЦ-ийг нэгдсэн загварт оруулах, автобусны зогсоолыг шинэчлэн тохижуулах, ТҮЦ-ийг зай талбайг зохицуулах,
5	2015.01.27	01/45	Журамд батлагдсан дизайн, загвартай байна гэж заасны дагуу ажиллах ёстой бөгөөд “Эртний өргөө” ХХК, “Контейнер хаус” ХХК ТҮЦ-ийнхээ загвар дизайныг батлуулалгүйгээр иргэдтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа талаар гомдол ирүүлсэн тухай, Олон жил ТҮЦ ажиллуулж байгаа болон журамд заасан стандартын дагуу бүтээн байгуулалтын ажлын трасст ТҮЦ-ийн байршил нь ороогүй бол үйл ажиллагааг нь сунган, үргэлжлүүлэн ажиллах бодлого баримтлах тухай, Зөвлөлөөс шийдвэр гараагүй байхад “КИГ” ХХК иргэдээс урьдчилгаа авч байгаа тухай гомдол гарсан тул дээрх асуудалд анхаарлаа хандуулан дүүргийнхээ нутаг дэвсгэрт журмын хэрэгжилтийг хангуулах тухай,
6	2015.03.31	05/331	Батлагдсан тоонд багтаан ТҮЦ-ийг зураг төслийн дагуу шинэчлэн байршуулах, Автобусны зогсоолыг шинэчлэн тохижуулах, ТҮЦ-ийг зай талбайг зохицуулах тухай,
7	2015.05.16	01/802	Автобусны зогсоолд ТҮЦ байрлуулах зөвшөөрөл олгохгүй байх, одоо байршиж байгаа ТҮЦ-ийг өөр газар холдуулан шилжүүлэх тухай,
8	2015.10.27	01/1636	Сонин борлуулах цэг ажиллуулж байсан иргэдийн үйл ажиллагааг дэмжиж ТҮЦ-ийг хуучин байршил дээр нь байршуулах тухай,
9	2015.10.27	01/1637	ТҮЦ ажиллуулж байгаа иргэдийн эрх ашиг хөндөгдөж байгаа талаар гомдол ирж байгаа тул иргэдэд хуучин байршил дээр нь зөвшөөрөл олгох, мөн 1 иргэнд 1 ТҮЦ ажиллуулах зөвшөөрөл олгох, бусдад түрээслэхгүй байх, ТҮЦ явган зорчигчийн замд саад болохгүй байх, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлөхгүй байх, иргэд оршин суугчдын тав тухыг алдагдуулахгүй байх зэрэг шаардлагыг хангаж ажиллах тухай.

Эх сурвалж: Нийслэлийн ХХҮХ-ийн ажлын баримт

“Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ын 1.3-т “түргэн үйлчилгээний цэг эрхлэгчид нь тухайн дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн даргатай гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна” гэж заасан боловч ямар шалгуурыг хангасан иргэдтэй нээлттэй, ил тод байдлыг хэрхэн хангаж гэрээ байгуулах тухай зохицуулж өгөөгүй байна.



ДӨРӨВ. Өрсөлдөөнийг хязгаарласан нь иргэдийг хохироох нөхцөлийг бүрдүүлжээ

4.1. “КИГ” ХХК-ийн захирал Д.Мөнхбат 2013 оны 3/55 дугаар албан бичгээр ТҮЦ нийлүүлэх хүсэлтийг НЗД-д гаргаж, албан ёсоор шийдвэр гаргаагүй байхад зөвхөн албан бичгийн хяналтын хуудсан дээрх ЗД-ын гарын үсгийг ашиглан ТҮЦ хийхээр гэрээ хийж, урьдчилгаа төлбөр авч, гэрээний дагуу ТҮЦ нийлүүлээгүйгээс иргэдийг хохироосон байна.

Нийслэлийн Засаг дарга 2013 онд “КИГ” ХХК-ийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авахуулах” тухай А/1030 захирамж гарган холбогдох байгууллагад хүргүүлж байсан байна.

Дээрх захирамжийг биелүүлэлгүй УБ хотын ЗАА “КИГ” ХХК-ийн захиалгаар боловсруулсан ТҮЦ-ийн загварын шийдлийг “журмын шаардлага хангасан” гэх шалтгаанаар батлуулсан, дүүргийн ХҮЗЗ-ийн дарга болон хэлтсийн мэргэжилтэн нарт энэ компанийн хийсэн ТҮЦ-ийг байршуулах, хамтран ажиллах чиглэл өгсөн байна. Тухайлбал:

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас журмын хэрэгжилтийг хангуулахаар Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газарт “түргэн үйлчилгээний цэгийг загварыг 2014 оны 5 дугаар сарын 10-ны дотор баталж ирүүлэх” талаар 2014 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 01/663 дугаар албан бичгээр хандаж,
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний газар нь 2014 оны 7 дугаар сарын 04-ны өдрийн 10/1964 дугаар албан бичгээр загварыг баталж хүргүүлсэн боловч энэ загвараар хийгдээгүй, Нийслэлийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга “КИГ” ХХК-ийн захирал Д.Мөнхбатад 2015 оны 05/94 дугаар албан бичгээр “Хамтран ажиллах санал” хүргүүлэхдээ “КИГ” ХХК-ийн ТҮЦ-ийг байршуулах тухай,
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2014 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 01/1105 дугаар албан бичгээр НЕТГ-т дахин түргэн үйлчилгээний цэгийг загварыг батлуулахаар хандахдаа дээрх журмын 2.1.5-д заасан “зөөврийн бие засах суултуур бүхий ариун цэврийн өрөөтэй байх”-гэсэн шаардлага хангагдаагүй боловсруулсан зураг, захиалагчийн эрхийг зөрчсөн гэж үзэж ариун цэврийн өрөөг шийдсэн загвартайгаар 7 дугаар сарын 10-ны дотор боловсруулж ирүүлэхийг мэдэгдэж байсан,
- Нийслэлийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс НЕТГ-т 2014 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 07/2200 дугаар албан бичгээр ...журмаар тогтоосон стандарт шаардлагад нийцүүлж “КИГ” компаниас ирүүлсэн ТҮЦ-ийн зургийн төслийг баталгаажуулахгүй байгаа тухай гомдол ирүүлсэн...-ийг, шийдүүлэхээр шилжүүлсэн дагуу “КИГ” ХХК-ийн санал болгосон “БУТОЗМ” ХХК, “МОНТРАК” ХХК-ийн боловсруулсан ТҮЦ-ийн 2 загварыг баталгаажуулсан,
- “КИГ” ХХК -ийн захиралд 2015 оны 05/20 дугаар албан бичгээр 9 дүүргийн худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлд үүрэг өгсөн талаар, Хотын А, Б бүсэд өмнө нь байрлаж байсан ТҮЦ-ийг жигдрүүлж нэгдсэн загварт оруулах ажлыг зохион байгуулахыг мэдэгдэж байжээ.

Энэ нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7-д "аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн шийдвэр" гаргахыг хориглосон заалттай нийцээгүй үйл ажиллагаа гаргасан байх тул хууль хяналтын байгууллагаар шалгуулах зүйтэй байна.

4.2. ЗАА-ны ХХҮХ-т “КИГ” компанийн нийт худалдсан ТҮЦ-ийн тоо, мэдээ байхгүй, харин 21 иргэнд холбогдох 164.9 сая төгрөгийн хохирол учруулсан тухай судалгааг ирүүлсэн болно.



Аудитын явцад иргэдийн өргөдөл, гомдол болон санамсаргүй сонголтоор иргэдтэй уулзалт хийж ярилцлага авахад “КИГ” ХХК-иар ТҮЦ хийлгэхээр 18 иргэн урьдчилгаа төлбөр хийсэн, үүнээс 9 иргэн ТҮЦ-ээ авсан боловч чанаргүй, 8 иргэн 65.8 сая төгрөг төлсөн ч ТҮЦ-ээ авч чадаагүй, 10.0 сая төгрөгөөр 1 иргэн ТҮЦ хийлгэсэн нь чанар муу, ханыг нимгэн хийснээс зүсэж хулгай орсноор эд материалаар хохирсон тухай мэдээлснийг баталгаажуулж шалгасан байна.

Зураг №2 “КИГ” ХХК-ийн хийсэн чанар муу ТҮЦ-ийн зураг



Эх сурвалж: Аудитын багийн авсан зураг

4.3. Аудитын явцад хөрөнгийн үнэлгээний “ЭМ КЭЙ ТИ АР ЭС” ХХК-иар “КИГ” ХХК-ийн хийсэн 13 дугаар хорооллын Бөхийн өргөөний орчим болон баруун 4 замд байрлах 12м² хэмжээтэй, загвар бүхий 2 ТҮЦ-ийг сонгон үнэлгээ хийлгэхэд 4.3-7.5 сая төгрөгөөр үнэлсэн байна. Дүгнэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №3 ЭМ КЭЙ ТИ АР ЭС” ХХК-ийн хийсэн үнэлгээний тайлан

	Үнэлгээний арга	Өртгийн хандлагын аргын үнэлгээний дүн /төг/	Зах зээлийн харьцуулах аргын үнэлгээний дүн /төг/
1	13 дугаар хорооллын Бөхийн өргөөний орчмын ТҮЦ	4,255,950	5,000,000
2	Баруун 4 замын ТҮЦ	4,255,950	7,500,000

Эх сурвалж: “ЭМ КЭЙ ТИ АР ЭС” ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайлан

УБ хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс үнийн судалгаа хийх, сонгон шалгаруулалтгүйгээр нэг компанийн загвараар хийлгүүлэх чиглэл өгсөн нь тухайн компанид 8.0-15.0 сая төгрөгөөр үнэлж борлуулах боломжийг олгосон, иргэд хохироход зохих хэмжээгээр нөлөөлсөн байна.



ТАВ. Орон нутгийн төсөвт түргэн үйлчилгээний цэгээс газар ашигласны төлбөр, хүн амын орлогын албан татвар, зарим дүүрэгт хураамжийн орлого төвлөрүүлдэг байна

5.1. “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-д гэрээний хураамж авах талаар зохицуулалт тусгаагүй, зарим дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасан эрх хэмжээний хүрээнд тухайн дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэнтэй үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулсны хураамж авахаар шийдвэрлэсэн байна.

5.2. Дээрх заалтыг үндэслэн БГД, СБД, СХД-ийн ИТХ тогтоол гарган дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэнтэй үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулсны хураамж авах, хураамжийн хэмжээг тогтоосон байна.

Гэрээ байгуулсны хураамжийн хэмжээ болон 2015-2016 онд дүүргийн ЗДТГ-ын үйл ажиллагааны орлогын дансанд 3.5 сая төгрөгийг төвлөрүүлснийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №4 Гэрээ байгуулсны хураамжийн хэмжээ болон төлсөн байдал

Д/д	ИТХ-ын тогтоол	Огноо	Дугаар	Хураамжийн хэмжээ /төг/	Гэрээний хураамж /төг/	
					2015	2016
1	БГД-ийн ИТХ	2014.12.12	58	10,000	280,000	920,000
2	СХД-ийн ИТХ	2014.04.14	A/40	15,000	1,035,000	300,000
3	СБД-ийн ИТХ	2016.03.20	15	20,000	1,000,000	-
	Нийт				2,315,000	1,220,000

Эх сурвалж: Нийслэлийн ХХҮХ-ийн ажлын баримт

Харин ХУД-ийн ХҮЗЗ худалдаа, үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулаагүй, ЧД, БЗД-т худалдаа, үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулсан ч гэрээний хураамж тогтоож аваагүй байна.

5.3. Газрын төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйл, НИТХ-ын 2010 оны 5/39 дугаар тогтоолын дагуу нийтийн эзэмшлийн газар дээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс газар эзэмшиж, ашигласны төлбөрийг дээд хэмжээ буюу 1 м² газарт сар бүр 440 төгрөг байхаар тогтоож, улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон байна. 2013-2016 оны газрын төлбөрийг 2016 оны 4 дүгээр сарын 19-ний байдлаар хүснэгтээр харуулав.

Хүснэгт №5 2013-2016 оны газрын төлбөрийн хэмжээ

№	Дүүрэг	2013 он		2014 он		2015 он		2016 он	
		Тоо	Төлөгдсөн дүн	Тоо	Төлөгдсөн дүн	Тоо	Төлөгдсөн дүн	Тоо	Төлөгдсөн дүн
1	БЗД	73	8,064,042	89	16,881,636	537	69,380,963	86	7,523,454
2	ХУД	28	4,338,280	27	5,420,680	38	5,872,260	39	4,846,810
3	БГД	114	16,870,824	135	17,901,998	125	24,897,106	173	28,112,890
4	СХД	139	16,885,887	122	18,872,642	69	8,707,620	113	16,159,485
5	ЧД	77	12,879,012	67	8,301,718	58	6,234,759	66	7,786,830
6	СБД	59	9,569,691	58	6,605,793	81	11,132,191	38	3,892,245
	Нийт	490	68,607,736	498	73,984,467	908	126,224,899	515	68,321,714

Эх үүсвэр: Нийслэлийн газрын албаны тайлан



Нийслэлийн газрын албанаас ирүүлсэн судалгаанаас харахад 2013-2016 онуудад 68.3 сая төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.

Харин ТҮЦ-ээс газрын төлбөрийн хураамж төлсөн эсэхэд нарийвчилсан судалгаа дүүргийн ХҮХ-т байхгүйгээс аудитын явцад орон нутагт төвлөрүүлэх газрын төлбөрийн дүнг тодорхойлох боломжгүй байлаа.

Холбогдох байгууллагын санал:



УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ц.Жигжиджавын гудамж 9, Хангарди ордон,
Утас/Факс: (976-11) 31-53-47, <http://www.ubservice.mn>

2017.05.10 № 01/771
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.АЛТАНЗУЛ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

"Нийслэлд хэрэгжсэн зарим төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт, хууль, тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн гаргасан дүгнэлтэд дараах саналыг гаргаж байна.

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журмыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс зөвхөн нэг компаний боловсруулсан загварын шийдлийг хүлээн зөвшөөрч журамд тусгасан нь Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний газраас гаргаж, баталсан дизайн, загвартай байх журмын шаардлагыг зөрчсөн гэх дүгнэлтийн тухайд:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журмын 2 дугаар зүйлд Түргэн үйлчилгээний цэгт тавигдах шаардлагуудыг тусгасан бөгөөд 2.1.3-т Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний газраас гаргаж, баталсан дизайн, загвартай байна гэж заасан бөгөөд аль нэг хуулийн этгээдийг болон түүний боловсруулсан загварыг тухайлан нэр заасан заалт энэ журамд байхгүй.

Улаанбаатар хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг нийслэлийн нутаг дэвсгэрт нэгтгэн зохион байгуулах чиг үүрэгтэй байгууллага нь Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар юм. Энэ чиг үүргийхээ дагуу ямар хуулийн этгээдийн боловсруулсан ТҮЦ-ийн загварыг батлах нь Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын эрхийн асуудал бөгөөд журмын 2.1.3-т заасны дагуу Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас баталсан загварыг мөрдөж ажиллаж байгаа нь зөвхөн нэг компаний боловсруулсан загварын шийдлийг хүлээн зөвшөөрч Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7-д заасан аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг хориглосон заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй юм.

1110301259



2. Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журмыг баталж гаргахдаа Хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний нэгдсэн санд бүртгүүлээгүй нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын заалтад нийцүүлээгүй, мөн нөлөөллийн шинжилгээ хийгээгүй боловсруулсан гэх дүгнэлтийн тухайд:

Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын Онцгой зохицуулалт буюу 6 дугаар зүйлийн 6.1-т Шийдвэрийн улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх, нийтэд мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурал... - аас гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг энэ журамд заасан хугацаанд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, шийдвэр нь хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа тохиолдолд тухайн байгууллагад зөвлөмж хүргүүлж болно гэж заасан бөгөөд ямар нэг хууль, тогтоомжтой зөрчилдсөн, хэм хэмжээ тогтоосон акт гаргах ажиллагааг хийгээгүй гэх зөвлөмж эрх бүхий байгууллагаас ирээгүй бөгөөд дээрх заалтын дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага НИТХ-аас гарсан хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэдэггүй зөвхөн зөвлөмж өгдөг байсан байна.

Мөн журмын 1 дүгээр хэсгийн 1.6.3, 2 дугаар хэсгийн 2.3.9, 2.4.1-т заасны дагуу хуулиар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах тусгайлан эрх олгогдсон байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх асуудлыг хариуцан ажиллах зохицуулалттай.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь хэм хэмжээ тогтоосон шийдвэр батлан гаргах эрх бүхий байгууллага биш юм.

Иймд Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам зөрчсөн гэх дүгнэлт үндэслэлгүй бөгөөд тус албанд хамааралгүй болно.

3. Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс нь КИГ ХХК-ийн хийсэн ТҮЦ-ийн загварыг журмын шаардлага хангасан гэж үзэн байршуулах шийдвэр гаргасан гэх дүгнэлтийн тухайд:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллагыг Захиргааны байгууллага гэж, 3.1.2-т Захиргааны байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг төрийн албан хаагчийг Захиргааны албан тушаалтан гэж тодорхойлсон.

Дээрх тодорхойлолтын дагуу КИГ ХХК-ийн хийсэн загварын ТҮЦ-ийн загварыг байршуулах тухай Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтны ямар нэг шийдвэр гараагүй бөгөөд тус албаны нэгжийн даргын албан бичиг нь захиргааны байгууллагын болон захиргааны албан тушаалтны шийдвэр биш юм.



4. Аудитын дүгнэлтийг ТҮЦ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах Төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй уулзахгүйгээр нэг талыг барьсан, захиргааны байгууллага, албан тушаалтныг буруутгах гэсэн, асуудлын шалтгаан нөхцлийг тал бүрээс нь бодит тайлбар авч судлан үзээгүй, найруулгын алдаатай, захирамжлалын баримт бичгийн болон байгууллага, нэгжийн нэршлийг буруу бичиж ирүүлсэн байна.

Иймд танай байгууллагын 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 2/891 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх үндэслэлгүйг үүгээр хүргүүлж байна.

Жич: Дүгнэлтийн 3, 5 дугаарт заасан асуудлыг чиг үүргийн дагуу холбогдох байгууллагад хандах хэрэгтэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ФАНТӨМӨР



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас ирүүлсэн саналын хариу

Санал: 1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журмын ТҮЦ-д тавигдах шаардлагуудыг тусгасан бөгөөд 2.1.3-т Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний газраас гаргаж, баталсан дизайн, загвартай байна гэж заасан бөгөөд аль нэг хуулийн этгээдийг болон түүний боловсруулсан загварыг тухайлан нэр заасан заалт энэ журамд байхгүй. УБ хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг нийслэлийн нутаг дэвсгэрт нэгтгэн зохион байгуулах чиг үүрэгтэй байгууллага нь НЕТГ юм. Энэ чиг үүргийнхээ дагуу ямар хуулийн этгээдийн боловсруулсан ТҮЦ-ийн загварыг батлах нь НЕТГ-ын эрхийн асуудал бөгөөд журмын 2.1.3-д заасны дагуу НЕТГ-аас баталсан загварыг мөрдөж ажиллаж байгаа нь зөвхөн нэг компанийн боловсруулсан загварын шийдлийг хүлээн зөвшөөрч Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7-д заасан аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг хориглосон гэх заалт үндэслэлгүй гэжээ.

Тайлбар:1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 99 дугаар тушаалаар батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалд заасан дагуу өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх”-д нөлөөллийн шинжилгээ хийгээгүй боловсруулсан нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмыг зөрчиж гаргасан учраас тухайн журам нь нийтдээ хүчин төгөлдөр бус захиргааны акт юм.

ЗАА-ны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс нь Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас боловсруулсан ТҮЦ-ийн загварын шийдлийг хүлээн зөвшөөрөлгүй, нэг компанийн боловсруулсан загварыг, батлуулахыг дэмжсэн үйл ажиллагаа явуулсан нь аудитын явцад нотлох баримтаар баталгаажсан. /Аудитын тайлангийн 1.1-1.3, 4.1-ээс үзнэ үү.

УБ хотын ЗАА “КИГ” ХХК-ийн захиалгаар боловсруулсан ТҮЦ-ийн загварын шийдлийг “*журмын шаардлага хангасан*” гэх шалтгаанаар батлуулсан, дүүргийн ХҮЗЗ-ийн дарга болон хэлтсийн мэргэжилтэн нарт энэ компанийн хийсэн ТҮЦ-ийг байршуулах, хамтран ажиллах чиглэл өгсөн нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7-д заасантай нийцэхгүй үйл ажиллагаа болсон гэж үзсэн.

Санал: 2 Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын Онцгой зохицуулалт буюу 6 дугаар зүйлийн 6.1-д Шийдвэрийн улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх, нийтэд мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурал... -аас гаргадаг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг энэ журамд заасан хугацаанд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, шийдвэр нь хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа тохиолдолд тухайн байгууллагад зөвлөмж хүргүүлж болно гэж заасан бөгөөд ямар нэг хууль



тогтоомжтой зөрчилдсөн, хэм хэмжээ тогтоосон акт гаргах ажиллагааг хийгээгүй гэх зөвлөмж эрх бүхий байгууллагаас ирээгүй бөгөөд дээрх заалтын дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага НИТХ-аас гарсан хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэдэггүй зөвхөн зөвлөмж өгдөг байсан байна.

Мөн журмын 1 дүгээр хэсгийн 1.6.3, 2 дугаар хэсгийн 2.3.9, 2.4.1-т заасны дагуу хуулиар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах тусгайлан эрх олгогдсон байгууллага улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг хариуцан ажиллах зохицуулалттай. Улаанбаатар хотын ЗАА хэм хэмжээ тогтоосон шийдвэр батлан гаргах эрх бүхий байгууллага биш юм. Иймд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам зөрчсөн гэх дүгнэлт үндэслэлгүй бөгөөд тус албанд хамааралгүй болно гэжээ.

Тайлбар: 2 Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга нь:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26.1-д “Аймаг, **нийслэлийн Засаг дарга нь** харьяалах нутаг дэвсгэртээ **төрийн удирдлагыг хэрэгжүүлэх** чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч” болохыг,
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд Нийслэлийн удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан ёсоор бүрдүүлж хэрэгжүүлэхээр,
- мөн **Нийслэлийн Засаг дарга** нь Улаанбаатар хотын захирагч байх бөгөөд тэрээр хотын аж ахуйг биечлэн зохион байгуулах, **мэргэжлийн албадыг зохицуулан удирдах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулахаар,**
- **Хотын ерөнхий менежер нь** Улаанбаатар хотын захирагчийн удирдлага дор ажиллахаар, Улаанбаатар хотын **захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа** байхаар,
- мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д удирдлагын бүрэн эрхийг заахдаа нийслэлтэй холбогдсон асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн бие даан шийдвэр гаргах,
- мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д нийслэлд хэв журам сахиулах, хотын аж ахуй, оршин суугчдын нийгэм, соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтэд хяналт тавих гэж тус тус заажээ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан дагуу нийслэлийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн хувьд мэргэжлийн албадыг зохицуулан удирдах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулаж Нийслэлийн Захирагчийн ажлын албыг байгуулан, удирдлагаар ханган ажиллуулж байгаа нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “захиргааны байгууллага” гэж **нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллагыг** захиргааны байгууллага гэж тодорхойлсон дагуу **Нийслэлийн Захирагчийн ажлын алба нь захиргааны байгууллага** юм.



Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д ... “захиргааны байгууллага, **албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан** захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан үйл ажиллагааг захиргааны актад хамааруулна” гэж заасны дагуу Нийслэлийн Захирагчийн ажлын алба, түүний албан тушаалтнаас амаар болон бичгээр гаргаж буй шийдвэр нь захиргааны актад хамаарч байна.

НИТХТ-ийн 2014 оны 56 дугаар тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ыг боловсруулахдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 99 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-д заасан дагуу өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх”-д нөлөөллийн шинжилгээ хийгээгүй боловсруулагдсан нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журамд нийцээгүй тухайн журам бүхэлдээ хүчин төгөлдөр бус байна.

Учир нь: “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын 1.6.4-т “Гадагш чиглэсэн” гэж тухайн байгууллагын дотоод зохицуулалтын шинжийг агуулаагүй, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас заавал дагаж мөрдөхөөр журамласан шийдвэрийг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэхээр дараах заалтуудад зааж өгсөн байна.Үүнд:

- журмын “Онцгой зохицуулалт” 6.1-д Шийдвэрийн улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх, нийтэд мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор иргэдийн **Төлөөлөгчдийн Хурал**...аас гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг энэ журамд заасан хугацаанд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, шийдвэр нь хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа тохиолдолд тухайн байгууллагад зөвлөмж хүргүүлж болно,
- “Энэ журмын 6.1-д заасан этгээд нь шийдвэрийн улсын нэгдсэн санд байгаа шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан, хүчингүй болсонд тооцсон шийдвэрийг энэ журамд заасан хугацаанд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”,
- мөн журмын 6.4-д “журмын 6.1-д заасан этгээд нь гаргасан шийдвэртээ нөлөөллийн шинжилгээ хийсэн байна”,
- мөн журмын 2.3.3. Шийдвэрийн төслийг бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийж, түүнд дараах нөхцөл байдлыг тусгаж, танилцуулга бэлтгэнэ,
- мөн журмын 2.3.3-ийн г-д хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх”-д нөлөөллийн шинжилгээ хийх,
- мөн журмын 2.5.2-д Шийдвэрийг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж



мөрдүүлнэ. Энэ шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзэж тухайн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага хүлээлгэхгүй.

Санал: 3 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллагыг Захиргааны байгууллага гэнэ гэж заасны дагуу 3.1.2-т Захиргааны байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг төрийн албан хаагчийг Захиргааны албан тушаалтан гэж тодорхойлсон.

Дээрх тодорхойлолтын дагуу “КИГ” ХХК–ийн хийсэн загварын ТҮЦ-ийг байршуулах тухай Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтны ямар нэг шийдвэр гараагүй бөгөөд тус албаны нэгжийн даргын албан бичиг нь захиргааны байгууллагын болон захиргааны албан тушаалтны шийдвэр биш юм гэжээ.

Тайлбар: 3 Тайлбар 2-ийг хамт үзэх, аудитын тайлангийн 6 дугаар хуудасны 1.1, 10 дугаар хуудасны 4.1-д үзнэ үү.

Санал:4 Аудитын дүгнэлтийг ТҮЦ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах Төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй уулзахгүйгээр нэг талыг барьсан, захиргааны байгууллага, албан тушаалтныг буруутгах гэсэн, асуудлын шалтгаан нөхцөлийг тал бүрээс нь бодит тайлбар авч судлан үзээгүй, найруулгын алдаа, захирамжлалын баримт бичгийн болон байгууллага нэгжийн нэршлийг буруу бичиж ирүүлсэн байна гэжээ.

Тайлбар: 4 Аудитын явцад ирүүлсэн ТҮЦ эрхлэгч иргэдийн өргөдөл, гомдол болон түүврийн аргаар биеэр уулзаж бодит байдлыг судлан үзсэн бөгөөд энэ талаар нотлох баримт авагдсан тул аудитын тайлангийн 11 дүгээр хуудасны 4.3-ыг үзнэ үү. Тайлангийн төсөлд найруулгын алдаа, захирамжлалын баримт бичгийн болон байгууллага нэгжийн нэршлийг буруу бичсэнийг аудитын чанарын хяналтаар зассан болно.



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.Үүнд:

1. НИТХТ-ийн 2014 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ыг баталж гаргахдаа Хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний нэгдсэн санд бүртгүүлээгүй нь тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын заалтад нийцүүлээгүй, мөн нөлөөллийн шинжилгээ хийгээгүй боловсруулсан байна.
2. УБ хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас боловсруулсан ТҮЦ-ийн загварыг дэмжилгүй, нэг компанийн саналаар боловсруулсан загварыг батлуулах, байршуулахыг дэмжсэн нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7 дахь заалттай нийцэхгүй байна.
3. Дүүргийн ХҮЗЗ ТҮЦ-ийн үйлчилгээ эрхлэгч нартай гэрээ байгуулаагүй, гэрээ байгуулсан ч дүгнэж сунгаагүй нь эрхлэгчдийн эрх ашигт нийцээгүй, БЗД, БГД, СБД-ийн ХҮЗЗ журмын заалтыг зөрчиж захирамжаар зөвшөөрөгдсөн байршилд давхардуулж, батлагдсан тооноос илүү байршуулах зөвшөөрөл олгосон зэрэг нь ТҮЦ-ийн тоог нэмэгдүүлсэн байна.
4. “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-д ТҮЦ эрхлэгчдийг ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулах талаар тусгагдаагүй, УБ хотын ЗАА албан бичгээр шийдвэрлэж байна.
5. УБ хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс үнийн судалгаа хийж, сонгон шалгаруулалтгүйгээр нэг компанийн загвараар хийлгэх чиглэл өгч тухайн компанид 8-15 саяар үнэлж борлуулах боломж олгосон нь иргэд хохироход зохих хэмжээгээр нөлөөлсөн байна.
6. Зарим дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасан эрх хэмжээнийхээ хүрээнд худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэнтэй үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулсны хураамж авахаар шийдвэрлэсэн, энэ нь харилцан адилгүй байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдагдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргад:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журмыг шинэчлэн боловсруулахдаа Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу нийгэм, эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ, тооцоо судалгаа хийж, хэрэгжих боломжтой, иргэдийн эрх ашиг, хууль тогтоомжид нийцүүлэн гаргах.
2. УБ хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс нэг компанийн саналаар боловсруулсан загварыг батлуулах, байршуулахыг дэмжсэн үйл ажиллагаа Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7 дахь заалтыг зөрчсөн байх магадлалтай байх тул хууль хяналтын байгууллагаар шалгуулах.
3. Дүүргийн Худалдаа, үйлчилгээний зохицуулах зөвлөл шинэчлэгдэн мөрдөгдөх “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-д заасан үүргийг хэрэгжүүлж, хууль тогтоомж зөрчсөн ТҮЦ эрхлэгч нартай холбоотой үйл ажиллагаа явуулахгүй байх.
4. ТҮЦ-ийг байршуулахдаа үйлчлүүлэгчдийн эрүүл ахуй, тохижилт, аюулгүй байдлыг хангаж, ТҮЦ эрхлэгчдийг ая тухтай хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлсэн байхаар зохион байгуулах.
5. Нийслэлийн нутаг дэвсгэрт байршиж буй ТҮЦ-ийн тоо, үйлчилгээ эрхлэх гэрээ болон газар ашигласны төлбөр хураамжийн судалгааг гаргаж, хяналт тавьж ажиллах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудитор А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Түргэн үйлчилгээний цэгийг өндөр үнээр иргэдэд худалдаж, зөвшөөрөлгүй газарт байршуулах нөхцөл бүрдүүлсэн эсэх болон хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн эрсдэлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албанд тус тус хүргүүлсүгэй.


3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Ц.Сандуй/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Батболд/, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга /Т.Гантөмөр/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газар /Б.Алтанзул/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



Түргэн үйлчилгээний цэгийг өндөр үнээр иргэдэд худалдаж, зөвшөөрөлгүй газарт байршуулах нөхцөл бүрдүүлсэн эсэх

[illegible]